
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн ... ¹¹ / ₁₅ ... тоот тушаалын гуравдугаар хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.02.11	Хуудасны тоо: 55
Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан <small>ШТА1659 1124050015 9048014</small>		Танилцах албан тушаалтнууд: Нийт багш, ажилчид	

НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ХЯНАХ ЖУРАМ

Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:
Хувилбарын дугаар: **V1.2026**

Түгээлт




Энэ журам нь манай байгууллагын өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ журмын батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

ЗӨВШӨӨРӨЛ

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү журмыг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
Боловсруулсан	ХАБЭА-н мэргэжлийн багш	Баярцэнгэл Сугирзав	2025.09.02	
Хянасан	Захиргаа, аж ахуйн менежер	Шоохуу Оюун-Ухаан	2026.01.19	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.02.10	

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмын өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт журамд орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

НЭГ.Нийтлэг үндэслэл.....	1
1.1. Зорилго.....	1
1.2. Хамрах хүрээ	1
1.3. Журмын хариуцагч	1
1.4. Товчилсон үгийн тайлбар	1-2
1.5. Нэр томъёо, тодорхойлолт.....	2-4
ХОЁР.Нөөцийн удирдлагын үйл явц	4-5
2.1. Нөөцийн удирдлагын үйл явц	5-9
2.2. Нөөцийн удирдлагын үйл явцын тайлбар	10
ГУРАВ.Хүний нөөцийн удирдлага.....	10
3.1. Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах үйл явцын схем	11
3.2. Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах үйл явцын схемийн тайлбар.....	11
ДӨРӨВ.Дэд бүтцийн нөөцийн удирдлага	12
4.1. Газар, талбай, барилга байгууламжийн нөөцийн бэлэн байдлыг хангах	12
4.1.1. Үйл явцын схем.....	Error! Bookmark not defined.
4.1.2. Барилга байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангах үйл явцын схемийн тайлбар.....	13-15
4.1.3. Барилга байгууламжийн нөөцийн ашиглалт	15-18
4.1.4. Барилга байгууламжийн ХЭМАБ-н шаардлага	19-22
4.1.5. Барилга байгууламжийн Байгаль орчны шаардлага	22-24
4.2. Тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах	24
4.2.1. Тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангах	24-26
4.2.2. Авто машин, тусгай зориулалтын машин механизм ашиглах.....	Error! Bookmark not defined.
4.2.3. Тоног төхөөрөмж, машин механизмын нөөцийн ашиглалтын НУТ-ны шаардлага	27-35
ТАВ.Ажлын орчны нөөцийн бэлэн байдлыг хангах үйл явц.....	Error! Bookmark not defined.
5.1. Үйл явцын схем.....	Error! Bookmark not defined.
5.2. Ажлын орчны нөөцөөр хангах үйл явцын схемийн тайлбар.....	Error! Bookmark not defined.
ЗУРГАА.Хэмжих, хянах хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг хангах үйл явц ...	Error! Bookmark not defined.
6.1. Үйл явцын схем.....	Error! Bookmark not defined.
6.2. Хэмжих, хянах хэрэгслээр хангах үйл явцын схемийн тайлбар.....	51
ДОЛОО.Байгууллагын мэдлэгийн нөөцийн бэлэн байдлыг хангах үйл явц.....	52-55

НАЙМ.Хамаарах бичиг баримт	55
ЁС.Хариуцлага	55
АРАВ.Маягт	55



№ Ж-3-017

Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-02-11

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Зорилго

Энэ журмын зорилго нь ISO9001:2015, ISO14001:2015, ISO45001:2018 стандартын 7.1 дэхь шаардлагыг биелүүлж, байгууллагын нэгдмэл удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтэнд шаардлагатай нөөцийг төлөвлөж, бэлэн байдлыг хангах үйл явцыг зохицуулахад оршино.

1.2 Хамрах хүрээ

Энэхүү журмыг Сургуулийн барилга байгууламжийн ашиглалт, хүний нөөцийн бүрдүүлэлт, техникийн бодлого, хөдөлмөрийн орчин нөхцөл, худалдан авалтын үйл ажиллагаанд мөрдөнө.

1.3.Журмын хариуцагч

1.3.1. Энэхүү журмын хэрэгжилтэд ХАБЭА-н ахлах мэргэжилтэн, Дотоод чанарын баталгаажилт, статистик судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн хяналт тавих ба хэрэгжилтийг зохион байгуулалтын нэгж бүр хариуцна.

1.3.2. Шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг ХАБЭА-н ахлах мэргэжилтэн, Дотоод чанарын баталгаажилт, статистик судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн /ажилтан/ захиралд танилцуулан шийдвэрлэнэ.

1.4.Товчилсон үгийн тайлбар

ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ЧУТ	Чанарын удирдлагын тогтолцоо
НУТ	Нэгдмэл удирдлагын тогтолцоо
БОУТ	Байгаль орчны удирдлагын тогтолцоо
Ч, ХАБЭА, БО	Чанар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ба байгаль орчин
ТТ	Тоног төхөөрөмж
ММ	Машин механизм
ББ	Барилга байгууламж
УТ	Удирдлагын тогтолцоо
ӨТММ	Өргөн тээвэрлэх машин механизм

	№ Ж-3-017	Баталсан огноо: 2026-02-11
	Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй

ХН	Хүний нөөц
АБ	Ажлын байр
АБТ	Ажлын байрны тодорхойлолт
ХЭМАБ	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал

1.5. Нэр томъёо, тодорхойлолт

Журамд ISO9001:2015, ISO14001:2015, ISO45001:2018 стандартын доорх нэр томъёонуудыг ашиглана. Энд дурдагдаагүй нэр томъёоны тодорхойлолтыг стандарт болон ХАБЭА-н тухай хуулийн агуулгаар ойлгоно.

- ISO9000:2015 стандартын 3.1.1. **Дээд удирдлага:** Дээд түвшинд байгууллагыг хянаж, чиглүүлж байдаг хүн буюу хүмүүсийн бүлэг.

Тайлбар: Дээд удирдлага нь байгууллага дотор өөрийн эрх мэдэл ба нөөцийг хуваарилан бусдад хариуцуулах хүчтэй.

Тайлбар: Хэрэв байгууллагын тогтолцооны хамрах хүрээ нь байгууллагын тодорхой хэсгийг л хамарч байгаа бол тухайн хэсгийг хянаж, чиглүүлдэг хүмүүсийг дээд удирдлага гэж ойлгоно.

- ISO9000:2015 стандартын 3.5.2. **Дэд бүтэц:** Байгууллагад хэрэгтэй барилга байгууламж, тоног төхөөрөмж ба үйлчилгээний тогтолцоо.

“Барилга”- Хөрстэй холбогдсон хүний байгуулсан олон жилийн үйлдвэрлэлийн ашиглалтанд зориулагдсан барилгын хийц.


“Барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээ.

- ISO9000:2015 стандартын 3.5.5. **Ажлын орчин:** Ажил гүйцэтгэгддэг нөхцлүүдийн цогц.

Тайлбар: Нөхцөл гэдэгт биет, нийгмийн, сэтгэл зүйн, байгаль орчны (агаарын хэм, гэрэл, ажлын байрны стресс, эргономик, цаг уурын хүчин зүйл, харж таньж болох биет байдал гэх зэрэг) хүчин зүйлс хамарна.

- ISO45001:2018 стандартын 3.3. **Ажилтан** – байгууллагын хяналт дор явагддаг ажил эсвэл ажилтай хамааралтай үйл ажиллагаанууд байгууллагын хяналт дор явагдана хувь хүн.

Тайлбар: Ажил эсвэл ажилтай хамааралтай үйл ажиллагааг янз бүрийн тохиролцоотойгоор, хөлстэй эсвэл хөлсгүй, байнга эсвэл түр, улирлаар эсвэл завсарлагаатай, жирийн эсвэл хагас цагаар гүйцэтгэж буй хүмүүс.

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

- ISO45001:2018 стандартын 3.6. **Ажлын байр** – байгууллагын хяналтанд байдаг, хүн байх шаардлагатай эсвэл ажил хийхээр очих шаардлагатай газар.

Тайлбар: Ажлын байрны талаарх байгууллагын үүрэг хариуцлага нь ажлын байранд тавих хяналтын түвшнээс хамаарна.

- ISO45001:2018 стандартын 3.14. **Бодлого** – дээд удирдлагаас албан ёсоор илэрхийлсэн байгууллагын чиглэл ба зорилт;

- ISO45001:2018 стандартын 3.23. **Чадамж** – зорьсон үр дүнд хүрэхийн тулд мэдлэг ба ур чадварыг хэрэглэх чадвар ;

- ISO45001:2018 стандартын 3.24. **Баримтжуулсан мэдээлэл** – байгууллагын хяналтанд байлгаж , мөрдөж хадгалвал зохих мэдээлэл ба түүний зөөгч;

- ISO45001:2018 стандартын 3.25. **Үйл явц**. Оролтуудыг гаралтанд шилжүүлдэг харилцан хамаарал эсвэл харилцан үйлчлэл бүхий үйл ажиллагаануудын багц;


- ISO45001:2018 стандартын 3.27. **Гүйцэтгэл** – хэмжигдэхүйц үр дүн;

- ISO45001:2018 стандартын 3.29. **Бусдаар гүйцэтгүүлэх** - байгууллагын чиг үүрэг эсвэл үйл явцын хэсгийг гадны байгууллагаар гүйцэтгүүлэхээр хийх тохиролцоо.

- ISO14001:2015 стандартын 3.2.1. **Байгаль орчин** – Агаар, ус, газар, байгалийн нөөц, ургамал, амьтан, хүн болон тэдгээрийн харилцан холбоог оруулан байгууллагын хүрээлэн буй орчин.

- ISO14001:2015 стандартын 3.2.2. **Байгаль орчны асуудал** – Байгаль орчинтой харилцан үйлчилдэг эсхүл харилцан үйлчилж болох байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний элемент.

- ISO14001:2015 стандартын 3.2.4. **Байгаль орчны нөлөөлөл** – Байгууллагын байгаль орчны асуудлуудаас бүхэлдээ эсвэл хэсэгчлэн шалтгаалж байгаль орчинд үзүүлэх эерэг эсвэл сөрөг аливаа өөрчлөлт.

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

Хоёр.Нөөцийн удирдлагын үйл явц

НУТ-ны 7.1.1-р бүлэгт шаардсан нөөцийн хэрэгцээ тодорхойлох, төрөл ба тоо хэмжээг тооцоолж төлөвлөх, нөөцөөр хангах ба хяналт тавих үйл явцыг дор үзүүлэв.

2.1.Нөөцийн удирдлагын үйл явц

Оролт	Үйл явц	Оролцогч талууд							Гаралт
		Захираал	ISO төлөөлөгч, менежер	Нэгж удирдлага	ИТА-ууд	Хүний нөөц	Сан хүү	Хангамж	
НУТ 7.1. Шаардлага	Нөөцийн хэрэгцээ тодорхойлох	Хяна	Хийх	Оролц	Оролц	Оролц	Хяна	Оролц	Хэрэгтэй нөөцийн жагсаалт
Нөөцийн хэрэгцээ	Нөөцийн тооцоолол хийх	Батлах	Оролц	Хийх	Оролц		Хяна	Оролц	Нөөцийн төрөл, тоо хэмжээ, үнийн тооцоо батлах
Нөөцийн тооцоолол	Худалдан авалт хийх, хангах		Оролц	Оролц			Хяна	Хийх	Хангалт
Хангалт	Нөөцийг ашиглах	Хяна		Хийх	Оролц	Оролц	Хяна	Оролц	Бүртгэл

	№ Ж-3-017	Баталсан огноо: 2026-02-11
	Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Хувилбар: V1.2026

Хяналт	Нөөцийн хүртээмжийг хянах	Хийх	Оролц	Оролц	Оролц	Хяна	Оролц	Бүртгэл

2.2.Нөөцийн удирдлагын үйл явцын тайлбар

1	Хэрэгтэй бүхий л нөөцийг тодорхойлох. Үүний тулд дараах нөөцийн асуултуудад хариулна.	
	7.1.1. Ерөнхий	<ul style="list-style-type: none"> Дотоод нөөц боломжоор хангах нөөц Гадны талаас авах нөөц
	7.1.2. Хүмүүс	<ul style="list-style-type: none"> НУТ-ны хэрэгжүүлэлтийн үйл явцад ямар ажилтнууд хэрэгтэй вэ? Үүргүүдийг тодорхойлох. НУТ-ны хяналтыг хэрэгжүүлэхэд ямар ажилтнууд хэрэгтэй вэ? Үүргүүдийг тодорхойлох. Байгууллагын бүтэц, албан тушаалын тоо ба зэрэглэл, ажилд авах процесс.
	7.1.3. Дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> Ямар барилга байгууламж, түүний хийц, бүтээц хэрэгтэй вэ? Ямар тоног төхөөрөмж, машин механизм хэрэгтэй вэ? Ямар программ хангамж, харилцаа холбооны болон тээврийн нөөц хэрэгтэй вэ?
	7.1.4. Ажлын орчин	<ul style="list-style-type: none"> Үйл явцуудыг хэрэгжүүлэхэд ямар ажлын орчин хэрэгтэй вэ? Бүтээгдэхүүн, үйлчилгээний шаардлага хангуулахад ямар ажлын орчин хэрэгтэй вэ? Ажлын орчин дотор, нийгмийн, сэтгэл зүйн, физикийн ямар хүчин зүйлс хэрэгтэй вэ?
	7.1.5. Хяналт ба хэмжилтийн нөөц	<ul style="list-style-type: none"> Бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлыг шалгахад ямар хянах, хэмжих нөөц хэрэгтэй вэ? Хяналт, хэмжилтийн үр дүн хүчин төгөлдөр, найдвартай байгааг баталгаажуулахад ямар шаардлага хангах хэрэгтэй вэ?

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

		<ul style="list-style-type: none"> • Хэмжих хэрэгслийг туршиж шалгах, тохируулга хийх, баримтжуулахад ямар хугацаа, стандарт, дүрэм шаардлагатай вэ? • Хяналт, хэмжилтийн нөөцийг зориулалтаар нь тасралтгүй ашиглахын тулд ямар шаардлага хангах хэрэгтэй вэ? 	
	7.1.6 Байгууллагын мэдлэг	<ul style="list-style-type: none"> • Үйл явцыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний тохирлыг хангахад ямар дотоод ба гадаад байгууллагын мэдлэг хэрэгтэй вэ? • Байгууллагын түлхүүр ажилтнууд хэн бэ? Тэдэнд байгууллагын ямар мэдлэг хадгалагддаг вэ? • Хэрэгцээний өөрчлөлтөнд нийцүүлэн байгууллагын мэдлэгийг өөрчлөх, шинэ мэдлэг олж авахад ямар арга хэрэгтэй вэ? 	
2		<p>Шаардлагатай нөөцийг жагсаасныхаа дараа шаардлагатай нөөцийн тоо хэмжээ, цаг хугацааг тооцоолно. Үйлдвэрлэлийн цикл, төслийн хугацаа, эсвэл байгууллагын бүхий л үйл ажиллагааны түвшинд гэсэн ангилалтайгаар тооцож болно.</p> <p>Дараах зүйлсийг тооцоолох хэрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> • Ажлыг хугацаанд нь дуусгахад шаардлагатай нийт үргэлжлэх хугацаа • Багийн хүн тус бүрт шаардагдах хугацаа • Тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангахад шаардах хугацаа • Багаж хэрэгслийн төрөл, тоо хэмжээ • Нэгж бүрт шаардлагатай түүхий материалын төрөл, тоо хэмжээ, бэлэн байх хэрэгтэй хугацаа • Техник хангамж, програм хангамж, харилцаа холбооны болон тээврийн хэрэгслийн төрөл, тоо • Шаардлагатай лиценз, гэрчилгээ, зөвшөөрөл, баталгаажуулалт ба тохируулга • Агуулахад эсвэл сургалтанд хэрэгтэй нөөцүүдийн хэвийн ажиллагааг шалгах, хянахад хэрэгтэй бусад нөөцийн төрөл, тоо хэмжээ • Хэвийн үйл ажиллагааг хангахад хэрэгтэй Байнгын нөөцийн тоо хэмжээ, татан авч байх цикл ба шинэчилж байх хугацаа. 	
3		<p>Нөөцийн тооцоололд үндэслэн, дотоод боломжоор хангах боломжтой нөөцөөр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p> <p>Мөн гадны талаас авах шаардлагатай нөөцийг худалдан авалтын процессын дагуу хэрэгжүүлж, нэгжүүдэд хангалт хийнэ.</p>	

	<p>№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй</p>
---	---	--

4	<p>Байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээний нийцлийг хангаж, байгаль орчны нөлөөлөл ба ХЭМАБ-н эрсдэлийг хянасан байдлаар барилга байгууламж, дэд бүтэц, ажлын орчноор хангах үүргийг байгууллага хүлээх ба хангасан нөөцийг зориулалтын дагуу зохистой ашиглах үүргийг хариуцсан нэгж бүр хүлээнэ.</p> <p>1/ Дэд бүтцийн нөөцийн бүрэн бүтэн байдал, хэвийн ашиглалт, элэгдэл хорогдол ба засвар үйлчилгээ хугацаандаа шаардлагын дагуу хийгдэж байгаа эсэхт Барилга байгууламжийн менежер, Аж ахуйн менежер, Механик инженер, НУТ-ны менежер хяналт тавьж, эрх бүхий засварчин, засвар үйлчилгээний ажилтан, эсвэл аутсорсингийн гэрээт байгууллагаар барилга байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ, засвар, үйлчилгээг цаг тухай бүрт хийлгэнэ.</p> <p>2/ Ингэхдээ, барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизм, программ хангамж, тээврийн хэрэгсэл, харилцаа холбооны технологи ба хэмжих ажиглах хэрэгслийн нөөцийн хэвийн ажиллагааны тухай мэдээлэл, эвсрэл гэмтлийн бүртгэл ба хийсэн засвар, үйлчилгээ, цэвэрлэгээнийн бүртгэлийг аж ахуйн менежер нэгтгэн, хадгална.</p> <p>3/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийцлийг хангахад шаардлагатай барилга байгууламж, зай талбай, тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгсэл, программ хангамж, холбоо харилцааны технологи, сүлжээ, ажлын орчин, хэмжих хянах хэрэгсэл, байгууллагын мэдлэгээр хангах, ашиглах үйл явцдаа тухайн нөөцийн байгаль орчны асуудал ба нөлөөлөл, хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдалтай холбогдолтой аюул, эрсдэл, боломжийг илрүүлэн бүртгэж, эрсдэлээс сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээг авна. Хууль тогтоомжийн болон гэрээний шаардлагуудыг мөн бүртгэн судалж, хангуулна.</p>
---	---



№ Ж-3-017


Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам


Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-02-11

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй



	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

	<p>5/ Нөөцийн шаардлага хангасан эсэхийг Үл тохирлын тоо, залруулсан арга хэмжээний тоо, нөөцийн найдвартай байдал, өртөг болон үйлчилгээний шаардлага хангаж буй түвшний хэмжих үзүүлэлтүүдээр хэмжинэ.</p> <p>Эдгээр шаардлагыг хангасан тухай баримтжуулсан мэдээллийг Барилга байгууламжийн менежер, Механик инженер, НУТ-ны менежер ба Аж ахуйн менежер нар нэгтгэн хадгална. Санхүүгийн алба хяналт тавина.</p>
5	<p>Хангасан нөөцийг зориулалтын дагуу зохистой ашиглаж байгаа эсэхт хяналт хийнэ. Техник, технологийн нөөцийг ИТА, хүний нөөцийг ХН-н алба, хэмжих ба хянах хэрэгслийн нөөцийг Чанарын алба, ХАБЭА ба БО-ны нөөцийг ХАБЭА, БО-ны алба хариуцан хяналт тавина.</p> <p>Хяналтаар алдаатай эсвэл дутагдалтай нөөц байгаа нь илэрвэл тэр даруй нөөцөөр хангаж, илүүдэл нөөцийн сангаас хангах буюу гадны талаас хангалт хийх шаардлагатай. Хэрэв техник технологийн нөөцийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан бол шаардлагын дагуу туршилт, тохируулга, баталгаажуулалтыг хийлгэх шаардлагатай.</p>


	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

Гурав.Хүний нөөцийн удирдлага

Энэхүү бүлэгт НУТ-ны 7.1.2-р бүлэгт заасан “Хүмүүс” буюу хүний нөөцийн шаардлагыг хангах үйл явцыг тодорхойлов.

3.1.Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах үйл явцын схем

Оролт	Үйл явц	Оролцогч талууд							Гаралт
		Захираал	ХАБЭА, БО	Нэгж удирдлага	ИТА - ууд	Хүний нөөц	Санхүү	Хангамж	
45001 7.1.2 шаардлага	Хүний нөөцийн төлөвлөлт	Батлах		Оролц		Хийх			ХН-н төл-гөө
Заавар	Ажлын Байрны шинжилгээ хийх		Оролц	Оролц	Оролц	Хийх			АБ-д хийх ажлууд
Ажлын Байрны шинжилгээ	АБТ боловсруулах		Оролц			Хийх			АБТ
АБТ (Ажлын байрны тодорхойлолт)	Сонголт хийх			Оролц	Хийх	Оролц			Бүртгэл
Бүртгэл	Сонгосон эсэх					Хийх			Тушаалын төсөл
Тушаалын төсөл	Томилох	Батлах				Хийх			Тушаал
АБТ	Сургах		Оролц	Оролц	Хийх				Тайлан
АБТ	Үнэлэх		Оролц	Хийх		Оролц			Үнэлгээ
Үнэлгээ	Давтан сургах		Оролц		Хийх				Тайлан

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах үйл явцын схемийн тайлбар

1	Хүний нөөцийн менежерүүд байгууллагынхаа тодохойлсон зорилго зорилт, үйлдвэрлэлийн дадлага болон үйлдвэр сургалт явуулахад шаардлагатай материал, түүхий эд, тоног төхөөрөмжийн тоо зэрэг мэдээлэлд үндэслэн хүн хүчний шаардлагатай нөөцөө урьдчилан төлөвлөнө. НУТ-ны хэрэгжүүлэлтийг хангуулахад шаардлагатай хүн хүчний тоо, ур чадварын түвшин, тусгай мэдлэг ур чадварын түвшинг мөн төлөвлөнө.
2	Ажиглалтын , баримт бичгийн , ярилцлагын гэх мэт аргуудаас сонгож, ажлын шинжилгээ хийж, тухайн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай чадавхийн түвшин, хийж гүйцэтгэх ажилбарууд, түүнийг гүйцэтгэхийн тулд ажилтанд шаардлагатай ажлын орчин нөхцөл, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл зэргийг тодорхойлно.
3	Ажлын шинжилгээний дүнд үндэслэн ажлын байр бүрийн АБТ-ыг ажлын байрны тодорхойлолт боловсруулах зааврын дагуу боловсруулна.
4	Ажлын байранд ажиллах ажилтанг сонгон шалгаруулах, ажлын байрны зар гаргаж, түүнд тухайн хүнд тавигдах шаардлагыг тусгана. Бүртгэгдсэн хүмүүсээс ажилд орохыг хүссэн өргөдлийг авч ерөнхий мэдлэг шалгах , мэргэжлийн болон ажил гүйцэтгэх чадварыг сорих тестээр шалгалт авна. Үүний дараа ажил горилогчтой ярилцлага хийж, уг ажлын байрны тодорхойлолтонд тавигдсан шаардлагыг хангасан гэж үзвэл хүний нөөцийн бүртгэлд бүртгэж авна.
5.	Ажлын байрны тодорхойлолтонд тавигдсан шаардлагыг хангасан хүнийг тухайн ажлын байранд ажиллуулах тушаалын төслийг бэлдэнэ.
6.	Ажил горилогчийг ажилд томилсон тухай захирлын тушаал гаргана.
7	Шинээр ажилд томилогдсон хүнд ХАБЭА-н урьдчилсан зааварчилгаа авна. Хөдөлмөрийн дотоод журам, ажлын чанарын хяналт, ажлыг хэрхэн аюулгүй гүйцэтгэх, хэрхэн байгаль орчны шаардлага ханган ажиллах талаар биечлэн үзүүлж зааж, сургалт өгч баримтжуулсанаар уг хүнд бие даан ажиллах эрх нээгдэнэ.
8.	Шинэ ажилтны бие даан ажлаа гүйцэтгэж байгаа байдалд ажиглалтын аргаар үнэлгээ хийж, дутагдалтай байгаа мэдлэг, ур чадварыг тодорхойлно.
9.	Шинэ ажилтанд дутагдалтай байгаа Ч, ХАБЭА, БО-ны мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх зорилгоор танхимын болон ажлын байран дээрх чадавхижуулах сургалтыг зохион байгуулна.

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

Дөрөв.Дэд бүтцийн нөөцийн удирдлага

Бүтээгдэхүүний шаардлагууд болон нийцлийн шаардлагыг хангахад шаардагдах барилга байгууламж, дэд бүтэц, ажлын орчныг тодорхойлж, хангаж, удирдаж, хадгалдаг. Дэд бүтцэд:


1. Газар, барилга, барилга байгууламж;
2. Тоног төхөөрөмж, машин механизм (техникүүд, програм хангамж, сүлжээ, тээврийн хэрэгсэл багтана);
3. Дэмжих үйлчилгээнүүд орно.

Энэхүү бүлэгт НУТ-ны 7.1.3-р бүлэгт заасан “Дэд бүтэц”-ийн нөөцийн газар, талбай, барилга байгууламжийн нөөцийн шаардлагыг хангах үйл явцыг тодорхойлов.

Байгууламжийн менежер нь Чанарын менежертэй хамтран байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн нийцлийг хангуулахын тулд дэд бүтэцтэй холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдлын аюулуудыг баримтжуулж, удирдаж, бууруулах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4.1.Газар, талбай, барилга байгууламжийн нөөцийн бэлэн байдлыг хангах

Тайлбар: Барилга байгууламжид, хуулийн шаардлагын дагуу дадлага, сургалт явуулахад эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг бүхэлд нь хамруулан үздэг тул программ хангамж, мэдээлэл харилцаа холбооны технологийн нөөцийг энэ бүлэгт хамруулан авч үзсэн.

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---


4.1.1. Үйл явцын схем

Оролт	Үйл явц	Оролцогч талууд							Гаралт
		Захирал	ХАБЭА, БО	Нэгж удирдлага	ИТА - ууд	Хүний нөөц	Чанар	Санхүү Хан Гамж	
45001 7.1.3 шаардлага	Газар, барилга, байгууламжийг бүртгүүлэх				Хийх				Паспорт
БнБДүрэм	Үзлэгийн төлөвлөгөө		Оролц	Оролц	Хийх				Төлөвлөгөө
Төлөвлөгөө	Үзлэг хийх		Оролц	Оролц	Хийх				Тайлан
Тайлан	Гэмтэл тогтоох			Оролц	Хийх				Бүртгэл
Бүртгэл	Зураг төсөл боловсруулах		Оролц		Хийх				Зураг төсөл
Зураг төсөл	Зөвшөөрөл авах				Хийх				Зөвшөөрөл
Зөвшөөрөл	тийм	Батлах			Хийх		Оролц		төсөв
Төсөв	Засварлах буюу барих			Оролц	Хийх		Оролц	Оролц	Актууд
Актууд	Хүлээн авах		Оролц	Оролц	Хийх				Актууд

4.1.2. Барилга байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангах үйл явцын схемийн тайлбар

	<p>№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй</p>
---	---	--


1	<p>Байгууллага нь өөрийн эзэмшлийн болон өмчийн газар, талбайг Улсын бүртгэлд хуулийн шаардлагын дагуу бүртгүүлнэ. Газар, талбайд хашаа барих, барилга байгууламж барих тохиолдолд дараах шаардлагыг хангуулна:</p> <p>Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.1.1-ийн дагуу ашиглалтад оруулсан барилга байгууламжид ашиглалтын гэрчилгээ авч, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг ИТА-ууд хариуцан гүйцэтгэнэ. Гэрчилгээ авахдаа барилгын тухай хуулийн дагуу доорхи баримт бичгүүдийг бүрдүүлсэн байна.</p> <p>48.5.1.барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл; 48.5.2.барилгын ажлын ил, далд ажлын акт; 48.5.3.зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт; 48.5.4.захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт; 48.5.5.барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэсэн, эсхүл өөр эх үүсвэр ашигласныг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл; 48.5.6.барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл; 48.5.7.тоног төхөөрөмж угсарсан актууд, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, тоног төхөөрөмжийг зааврын дагуу суурилсан эсэхэд хийсэн туршилтын дүгнэлт.</p>
2	<p>Байгууллага нь барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.3-т заасан техникийн үзлэг шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байдлаар зохион байгуулах бөгөөд төлөвлөгөөт үзлэгийг дор дурдсанаар ерөнхий болон хэсэгчилсэн байдлаар хийнэ:</p> <p>3.4.1. ерөнхий үзлэг шалгалтыг хавар, намрын улиралд тус бүр 1 удаа, тухайн барилга байгууламжийг ногоон байгууламж, авто зогсоол, гэрэлтүүлэг зэрэг орчны тохижилтын хамт бүхэлд нь хамруулан хийнэ; 3.4.2. хэсэгчилсэн үзлэг шалгалтыг ашиглах хугацааны явцад үүссэн эвдрэл гэмтлийг тогтоох зорилгоор барилгын эдлэхүүн, хийц хэсэглэл, орчны тохижилт гэсэн хэсэг тус бүрээр хийнэ. 3.5. Төлөвлөгөөт бус үзлэгийг гал түймэр, гамшиг, аюулт үзэгдэл учирсан тохиолдолд барилга байгууламжид гарсан эвдрэл гэмтлийг илрүүлэн арилгах зорилгоор хийнэ. 3.6. Барилга байгууламжийн төлөвлөгөөт үзлэгээр ашиглалтын явцад урсгал болон их засвар хийх хугацааг холбогдох норм, дүрэмд нийцүүлэн тогтооно.</p>
3	<p>Батлагдсан төлөвлөгөөний дагуу мэргэжлийн хяналтын ерөнхий газраас боловсруулсан “БАРИЛГЫН АШИГЛАЛТЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС”-ны дагуу барилгын ашиглалтын байдалд үзлэг хийнэ</p>
4	<p>Үзлэгийн үеэр барилга байгууламжийн ашиглалтад сөргөөр нөлөөлөх эвдрэл гэмтлийг тогтоож фото зургаар баримтжуулна. Үүнд барилга байгууламжийг барьсан газар, талбай ба түүний эргэн тойрны бүтэц, тогтоц, хөршүүд болон дамжин өнгөрөгчдийн нөлөө зэргийг хамруулан, ХЭМАБ ба Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ хийнэ. Бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлыг хангуулахад шаардлагатай аливаа хүчин зүйлд мөн Чанарын эрсдэлийн үнэлгээ хийнэ. Эрсдэлийн удирдлагын журмын дагуу эрсдлийг зэрэглэн, хяналтанд авна.</p>

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---


5.	Барилга байгууламжид хийгдэх цэвэрлэгээ, арчилгаа, үйлчилгээ, их болон урсгал засварын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
6.	<p>Барилгын хуулийн дагуу доорх материалуудыг бүрдүүлж барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авна.</p> <p>28.2. Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд дараахь баримт бичгийг хавсаргана:</p> <p>28.2.1. барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр;</p> <p>28.2.2. барилга байгууламжийн магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлт;</p> <p>28.2.3. зураг төсөл зохиогч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;</p> <p>28.2.4. байгаль орчны хууль тогтоомжийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай барилга байгууламжийн үнэлгээний тайлан;</p> <p>28.2.5. гэнэтийн ослын болон хариуцлагын даатгалд даатгуулсан бол гэрчилгээг хавсаргах.</p> <p>28.3. Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгээс гадна зураг төсөл боловсруулсан болон барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хавсаргана.</p> <p>28.4. Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсаргана.</p> <p>28.5. Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргасан этгээдийн хүсэлтэд хавсаргасан энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгийг хянан шийдвэрлэж, зөвшөөрөл олгоно</p>
7	Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авсны дараа засварын ажлыг мэргэжлийн байгууллагаар зураг төслийн дагуу гүйцэтгүүлнэ.
8.	<p>Барилгын засварын ажил дууссаны дараа доорх баримт бичгүүдийг бүрдүүлж ажлын гүйцэтгэлийн чанарыг шалгаж хүлээн авсан акт үйлдэнэ.</p> <p>48.5.1. барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл;</p> <p>48.5.2. барилгын ажлын ил, далд ажлын акт;</p> <p>48.5.3. зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт;</p> <p>48.5.5. барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэсэнийг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл;</p> <p>48.5.6. барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл;</p> <p>48.5.7. тоног төхөөрөмж угсарсан актууд, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, тоног төхөөрөмжийг зааврын дагуу суурилсан эсэхэд хийсэн туршилтын дүгнэлт.</p>

4.1.3. Барилга байгууламжийн нөөцийн ашиглалт

Байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээний нийцлийг хангаж, байгаль орчны нөлөөлөл ба ХЭМАБ-н эрсдэлийг хянасан байдлаар барилга байгууламжийн

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

нөөцөөр хангах үүргийг байгууллага хүлээх ба хангасан нөөцийг зориулалтын дагуу зохистой ашиглах үүргийг хариуцсан нэгж бүр хүлээнэ.



1/ Барилга, байгууламжийн хийц, бүтээц, бүрэн бүтэн байдал, хэвийн ашиглалт, элэгдэл хорогдол ба засвар үйлчилгээ хугацаандаа шаардлагын дагуу хийгдэж байгаа эсэхт Барилга байгууламжийн менежер эсвэл Аж ахуйн менежер хяналт тавьж, эрх бүхий засварчин, засвар үйлчилгээний ажилтан, эсвэл аутсорсингийн гэрээт байгууллагаар барилга байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ, засвар, үйлчилгээг цаг тухай бүрт хийлгэнэ.

2/ Ингэхдээ, барилга байгууламжид засвар, үйлчилгээ хийсэн бүртгэлийг аж ахуйн менежер хөтөлж, хадгална. Барилга байгууламжийн найдвартай байдал, өртөг буюу элэгдэл хорогдол, үйлчилгээ цэвэрлэгээ хийх шаардлага зэргийг санхүүгийн алба бүртгэж, аж ахуйн менежер мэдээлж байна. Цэвэрлэгээ, үйлчилгээний бодис болон засварын сэлбэг хэрэгслийн хэрэгцээг мөн аж ахуйн менежер бүртгэн, санхүүд мэдээлж, төсвийг батлуулна.

3/ Байгууллагын барилга байгууламж, газар, ажлын байр болон газар, талбайг Аж ахуйн менежер хариуцан хянаж, бүрэн бүтэн байлгах ба зориулалтын дагуу

	<p>№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй</p>
---	---	--

ашиглана. Цэвэрлэгээний ажилтнууд хуваарийн дагуу өдөр бүр цэвэрлэж, байгууллагын өөрийн болон гэрээт засвар үйлчилгээний инженерүүд засвар үйлчилгээг хийнэ.

Бүтээгдэхүүний шаардлагад нийцүүлэхэд шаардагдах ажлын орчныг зохих ёсоор хангана. Албан бус болон дүн шижилгээний уулзалтуудын үеэр барилга байгууламжид цаашид сайжруулах хэрэгцээ байгаа талаар хэлэлцэж, сайжруулах арга хэмжээ авахаар бүртгэнэ.

3.1/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийцлийг хангахад шаардлагатай барилга байгууламж, зай талбай, ажлын орчноор хангах, ашиглах үйл явцдаа тухайн барилга байгууламжийн байгаль орчны асуудал ба нөлөөлөл, хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдалтай холбогдолтой аюул, эрсдэл, боломжийг илрүүлэн бүртгэж, эрсдэлээс сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээг авна. Хууль тогтоомжийн болон гэрээний шаардлагуудыг мөн бүртгэн судалж, хангуулна. Мөн барилга байгууламжийн хийцлэл, материал, далд ажлын монтаж, схем зураг, онцгой байдлын үед аврах гарцын схем, галын болон бусад аюулаас хамгаалал тоноглол зэрэг анхаарах асуудлуудыг ХАБЭА болон Байгаль орчны албанаас тавих шаардлагыг хангуулсан байх үүрэгтэй.

Хэрэв байгууллагын ажилтнууд хууль тогтоомжийн шаардлага, хийцлэлийн болон инженерингийн шаардлагууд, ХАБЭА болон Байгаль орчны, Бүтээгдэхүүн үйлчилгээний тохирлын шаардлагуудыг нарийвчлан мэдэхгүй байгаа бол энэ тал дээр мэргэжлийн байгууллагын тусламж, зөвлөх үйлчилгээ, сургалт, үнэлгээ, аудитын ажлыг гэрээлэн авч, гүйцэтгүүлж болно.

3.2/ Барилга, байгууламж, ажлын зай талбай, газар, ажлын бүсийн орчмын дэд бүтэц нь хууль тогтооцийн нийцэл, гэрээний нийцэл, бүтээгдэхүүн үйлчилгээний тохирол, ХЭМАБ, БО-ны шаардлагад нийцсэн байх шаардлагатай. Энэ шаардагыг хангасныг нотлох бүртгэл, акт, тайлан, гадны талын үнэлгээний тайлан, байгууллагын аюул/асуудал, эрсдэл/нөлөөлөл, боломжийн бүртгэл, засвар үйлчилгээний бүртгэлүүдийг хадгална.

4/ Засвар үйлчилгээг засвар үйлчилгээний төлөвлөгөөний дагуу эрх ба мэдлэг ур чадвар бүхий засварчид гүйцэтгэнэ. Шаардлагатай бол хамтран ажиллах гэрээний дагуу гадны талаар аутсорсингоор, эсхүл гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

Шинэ байгууламж барих болон одоо байгаа байгууламжуудыг өөрчлөх төлөвлөлтийг ихэвчлэн ажиллах хүчин буюу хүчин чадлын нэмэгдэл, бүтээгдэхүүн, процессын өөрчлөлттэй уялдуулан гаргадаг. Мөн бүтээмж, чанар, ажлын орчныг сайжруулах үүднээс байгууламжуудыг өргөтгөж, өөрчилж болно.

 <p>ВМНЯГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ</p>	<p>№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй</p>
--	---	--

Байгууламжийг өөрчлөх, өргөтгөх тухай бүх хүсэлтүүдийг хамгийн доод түвшинд Албадын дарга нар, Ерөнхий инженер нар хянаж, батлах ёстой. Томоохон өөрчлөлт, өргөтгөлийн талаарх хүсэлтүүдийг Дээд удирдлага хянаж батлах ёстой.

5/ Барилга байгууламжийн нөөцийн шаардлага хангасан эсэхийг Үл тохирлын тоо, залруулсан арга хэмжээний тоо, нөөцийн найдвартай байдал, өртөг ба үйлдвэрлэлийн дадлагга, сургалтын шаардлага хангаж буй түвшний хэмжих үзүүлэлтүүдээр хэмжинэ.

Эдгээр шаардлагыг хангасан тухай баримтжуулсан мэдээллийг Барилга байгууламжийн менежер / Аж ахуйн менежер/ нэгтгэн хадгалж, НУТ-ны менежерт хянуулна.

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

4.1.4. Барилга байгууламжийн ХЭМАБ-н шаардлага

Барилга байгууламжийн аюулгүй ашиглалтыг хангуулахын тулд дараах шаардлагуудыг хангах ба үүгээр хязгаарлагдахгүй. Чанар, ХЭМАБ, БО-ны менежерүүд ба бусад талуудын шаардлагыг тухай бүр нэмж, шаардлагыг хангуулна.

1/ Ажлын байрны цахилгаан эрчим хүч

Бүх цахилгаан тоног төхөөрөмж, хангамжийн цэгүүдийг аюулгүй байдлаар ашигладаг ба ур чадвартай ажилтнууд "Ажлын байрны цахилгаан эрчим хүчний дүрэм 1989"-ийн дагуу аюулгүйн үзлэг шалгалтыг хийж, цахилгааны инженерүүд холбогдох журам, хуваарь, аюулгүй байдлын бусад хууль тогтоомжийг судална.

Ажилтнууд алдаатай цахилгааны хэрэгсэл болон гэмтлийг олж илрүүлсэн тохиолдолд нэн даруй Шугамын менежерт мэдээлж, засвар үйлчилгээг хийлгүүлэх, эсвэл үйлчилгээнээс хасуулах шаардлагатай. Ажилтнууд уг асуудлыг өөрсдөө засах гэж оролдож БОЛОХГҮЙ.

Ямар ч тохиолдолд ажилтнууд ажлын талбайд хувийн болон сургуулийн эзэмшлийн бус цахилгаан тоног төхөөрөмжийг авчрах ёсгүй. Цахилгаан тоног төхөөрөмжийг Шугамын менежерээр дамжуулан хүсэлт гарган, захиалж, нийлүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр төхөөрөмжийг шалгаж, Тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ бүртгэлд бүртгэх нөхцөл бүрдэнэ.

2/ Хамгаалалт


Манай барилга байгууламж, байрнуудад ажлын цагаар, зарим байрнуудад ажлын бус цагаар хяналт тавих хяналтын камерын систем суурилуулсан байдаг бөгөөд тэдгээр системд хамгаалалтын ажилтнууд жилийн бүх өдөр 24 цагаар хяналт тавьдаг. Бүх байранд гадны халдагчийг мэдээлэх дохиоллын систем байдаг бөгөөд бүх гол гарцуудыг нэвтрэх хяналтын системээр удирддаг.

Бүх ажилтнууд нууцлалын гэрээнд гарын үсэг зурж, ажилтны үнэмлэх зүүдэг.

Зочид болон, гэрээгээр ажил гүйцэтгэгчдийг өмнө нь зөвшөөрөл аваагүй л бол хараа хяналтгүйгээр талбайн аль ч хэсэгт оруулахыг хориглох ба үргэлж ажилтнуудтай хамт байлгах ёстой.

3/ Материал

Эрүүл Мэндэд Аюултай Бодисын Хяналтын Дүрэм 2002 (COSHH)-ийн дагуу эрүүл мэндэд хортой гэж тооцогддог бүх бодисыг үнэлж, эрүүл мэндэд учрах эрсдлийг зохих ёсоор хянадаг. Ур чадвартай ажилтнууд болон томилогдсон аюулгүй байдлын зөвлөхүүд нь COSHH үнэлгээний системийг ашиглан бүх бодисыг ашиглаж эхлэхээс өмнө үнэлдэг.

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

COSHH-ийн үнэлгээг 5 жил тутамд нэг удаа хийдэг бөгөөд ашиглаж буй бодист, түүнийг хэрэглэх аргад өөрчлөлт орсон эсэхийг хянана. Бодис бүрт дараах мэдээлэл бүхий мэдээлэх хуудсыг ашиглана:

1. Бодисын зохистой хэрэглээ;
2. Ашиглалтаас үүсч болзошгүй хор уршгийн үнэлгээ;
3. Бодисын хортой нөлөөг хязгаарлахад шаардагдах хяналтын тохиромжтой, практик арга хэмжээнүүд, шаардлагатай бол эдгээр хяналтын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаарх мэдээлэл;
4. Галын аюулгүй байдал, гал түймэртэй тэмцэх талаарх мэдээлэл
5. Шаардлагатай анхны тусламжийн арга хэмжээ, бодисоор амьсгалсан, залгисан, арьсанд шингэсэн гэх зэрэг тохиолдолд;
6. Асгарсан шингэнийг зохицуулах арга зам;
7. Бодистой харьцах, хэрэглэх үед шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл.

Ажилтнууд болон гэрээт ажилтнууд ямар ч тохиолдолд хэрэглэх зөвшөөрөл аваагүй ямар ч бодисыг ажлын байранд нэвтрүүлж, ашиглаж болохгүй.

4/ Хортон шавжийг хянах

Ажлын байранд мэрэгч амьтад/шавжны халдвар г.м хортон шавьжтай холбоотой асуудал үүссэн эхний тохиолдолд л Албаны даргад мэдээлэх ба тухайн дарга нь хортонтой тэмцэх бүртгэлтэй байгууллагыг ажлын байранд ирүүлэх ажлыг зохион байгуулна. Ямар нэг арга хэмжээ авахаасаа өмнө хортон шавжийг устгах явцад ашигласан аливаа хортой үйл явц, бодисын нөлөөг багасгах зорилгоор эрсдлийн үнэлгээг хийхийн тулд тэдгээр хортонтой тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагаас Мэдээлэх хуудас, тэмцэх аргын талаарх мэдэгдлийг авах ёстой.


5/ Хүний нөөц

5.1/ Байгууламжийн менежер

Байгууламжийн менежер буюу Аж ахуйн менежер нь Чанарын менежерийн дэмжлэгтэйгээр барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хөтөлбөрүүдийн байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын холбогдох нөлөөллийг удирдах ерөнхий үүргийг хүлээнэг. Хөтөлбөрт:

1. Тээвэрлэлт ба материалын зохицуулалт;
2. Тоног төхөөрөмжийн удирдлага, засвар үйлчилгээ;
3. Процессын болон дадлагын газрын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ;
4. Байгууламжийн удирдлага, засвар үйлчилгээ зэрэг орно.

5.2/ Анхны тусламж үзүүлэгчид

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

Эрүүл мэнд, аюулгүй байдлын дүрэм 1981 (Анхны тусламж) -ийн дагуу бүх байршилд Анхны тусламжийн хэрэгслээр хангадаг. Ажлын байранд осол болон өвчлөл гарсан тохиолдолд Мэргэшсэн анхны тусламжийн ажилтнуудтай холбоо барих ёстой. Анхны тусламж үзүүлэгчдийн одоогийн жагсаалтыг бүх ажлын талбай дах мэдээллийн самбаруудаас харах боломжтой. Бүх ажилтнууд өөрсдийн байрлаж буй хэсгүүд дэх анхны тусламжийн хэрэгслүүдтэй танилцах шаардлагатай.

Анхны тусламж үзүүлэгчид нь анхны тусламж эмчилгээг хийх ба анхны тусламжийн хайрцагт шаардлагатай бүх зүйлсийг байлгах үүрэгтэй. Тэдгээр ажилтнууд анхны тусламж үзүүлэх хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээтэй байх үүрэгтэй бөгөөд давтан сургалт шаардлагатай бол энэ талаар Хүний нөөцийн алба эсвэл Чанарын менежерт уламжилна. Анхны тусламж үзүүлэгч нар нь үзүүлсэн анхны тусламжийн үйлчилгээ бүрээ баримтжуулна.

5.3/ Гал хамгаалагчид

Барилга болон байршил тус бүрт Галын онцгой байдлын нүүлгэн шилжүүлэлтийн тодорхой заавар байрлуулсан байдаг. Тиймээс ажилтнууд өөрсдийн ажиллаж байгаа хэсгийн нүүлгэн шилжүүлэх журамтай танилцах нь маш чухал. Хэсэг тус бүрт галын зааварлагчийг томилдог. Галын зааварлагчдын жагсаалтыг Мэдээллийн самбаруудаас харах боломжтой. Галын зааварлагчид нь нүүлгэн шилжүүлэх арга техник, гал унтраах аюулгүй арга, гал унтраах багаж хэрэгслийг ашиглах сургалтанд хамрагдсан байга.

Ажилтнууд зөвхөн өөрт нь хэт их эрсдэл учруулахааргүй тохиолдолд л галыг унтраах оролдлого хийж болох ба ажилтны хувийн аюулгүй байдал бусад бүх зүйлээс дээгүүрт тавигдана.

Байгууламжийн менежер нь барилга байгууламжийн галын дуудлагын цэгүүдэд галын болон нүүлгэн шилжүүлэх журмыг байрлуулж, зочид, гэрээт ажилтнуудад танилцуулах үүрэгтэй. Байгууламжийн менежер нь Гал хамгаалагчидтай хамтран галын хаалгыг хаахад саад учруулж буй хаалт, саадуудыг олж зайлуулах, хаалгуудыг хаалттай байлгах арга хэмжээг авна.

Хэрэв хаалгыг онгорхой байлгах шаардлагатай бол хаалгыг тогтоон барих төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулах ба тухайн төхөөрөмж нь галыг илрүүлэх, дохиоллын системтэй холбогдсон, гал гарсан тохиолдолд хаагддаг тохируулгатай байна. Байгууламжийн менежер ба гал хамгаалагч нар нь онцгой байдлын үед барилгаас гарах зам дах бүх хаалгыг түлхүүр шаардлагагүйгээр шууд дотроос нь онгойлгох боломжтой байлгана.

Байгууламжийн менежер болон гал хамгаалагч нар барилгаас гарах бүх маршрутыг үргэлж саадгүй, цэвэр байлгаж, сар бүр шалгана. Барилгаас гарах замд

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

цаас, хайрцаг, хог хаягдал, хувцасны өлгүүр, тавилга, хувилах төхөөрөмж болон бусад шатамхай зүйлсийг байлгаж болохгүй.

Мөн ерөөнүүдийн дотоод зохион байгуулалтыг аюулгүйн гарц хүрэх зам саадгүй байлгахуйц, үүний тулд дэлгэц, кабинет зэргийг ашиглан хаалт үүсгэх байдлаар аюулгүйн гарц хүртэлх зам буюу урсгал тодорхой бөгөөд чөлөөтэй, шаардагдах хэмжээнээс хэтрээгүй байх нөхцлийг бүрдүүлнэ. Байгууламжийн менежер ба гал хамгаалагчид нь галын аюулгүй байдлын бүх тэмдэглээнүүд BS 5499-ийн 1-р хэсэгтэй нийцэж байгаа эсэхийг шалган баталгаажуулна. Бүх аюулгүйн гарц ба барилгаас гарах гарц болон эцсийн гарц зэрэгт тэмдэглэгээ байрлуулж, аялалын чиглэлийг тодорхой харуулсан байна.

Барилгаас гарах эцсийн гарц буюу хаалга нь гудамж эсвэл автомашины зогсоол руу нээгдэх тохиолдолд хаалганы гадна талд "Галын шат, саадгүй байлгана уу" гэсэн тэмдэглэгээ байрлуулна. Тэдгээр галын хаалгануудын тодор талд "Галын хаалга хаалттай байлгана уу" гэсэн тэмдэглэгээ байрлуулдаг. Галд тэсвэртэй хаалгатай цахилгаан шүүгээнд "Галын хаалга түгжээтэй байлгана уу" гэсэн тэмдэглэгээ байрлуулна.

4.1.5. Барилга байгууламжийн Байгаль орчны шаардлага


1/ Байгалийн хийн хамгаалалт

Байгууллага нь хийн хэрэгсэл/утааны суваг тус бүрт жил болгон шалгалт хийж, хийн хэрэгсэл, холбох хэрэгсэл, утааны яндангийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. Тэдгээр хийн бүх хэрэгслийн угсралт суурилуулалт, засвар үйлчилгээ, аюулгүй байдлын үзлэг шалгалтыг " Аюулгүй Хийн " бүртгэлтэй инженер гүйцэтгэнэ.

Байгууламжийн менежер аюулгүй байдлын шалгалтын бүртгэлийг хамгийн багадаа хоёр жил хадгална. Байгууламжийн менежер системийн хамгийн өндөр үр ашиг, хамгийн бага ашиглалтын зардалтай ажиллагааг хангуулах үүднээс төвийн дулааны болон бусад төхөөрөмж хэрэгслийн хэвийн бөгөөд сайн ажиллагааг хангуулж, урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний хуваарийг гарган ажиллана.

2/ Усны хэмнэлт

Байгууламжийн менежер нь усны нөөцийг хэмнэх, усны хэрэглээг оновчтой болгох хяналтыг суурилуулах, ариун цэврийн өрөө, шүршүүрт усны хэрэглээг багасгахад шаардагдах бүх арга хэмжээг авна. Хэрэв танай байгууллага усны хэрэглээний зардлын өндөр дүн бүхий нэхэмжлэх хүлээн авбал тэр даруй шалгана. Шалгалтыг аль түвшинд хийх болон цагийн хуваарь зэргийг усны хэтрүүлэн хэрэглэсэн хэмжээнээс хамаарч тогтооно. Усны алдагдлыг цаг алдалгүй олж

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

засахын тулд зарим усны тоолуур дээр пульсийн унтраалга (тоолуурын автомат заалтыг) суурилуулна.

3/ Цахилгааны хэмнэлт

Ажилтнууд ажлын өдөр дуусахад хувилах төхөөрөмж, принтер, компьютер зэрэг бүх оффисын тоног төхөөрөмж, мониторуудыг унтраана. Ажлын цагуудад бүх компьютерүүдийг хамгийн бага цахилгаан зарцуулах горимд ажиллуудаг ба зарим тодорхой компьютерүүдийг цахилгааныг удирдах тохируулгатайгаар ажиллуулна.

- Доторх гэрэлтүүлгийг гэрлийн тоо, ваттын хэмжээг бууруулах замаар багасгах боломжтой ба тухайн орон зайд гүйцэтгэж буй ажлын шаардлагад тохируулан гэрэлтүүлгийг хамгийн бага боловч хангалттай түвшинд байлгана.
- Тохиромжтой бөгөөд шаардагдах санхүүжилт нь хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд бол одоогийн дотоод болон гаднах гэрэлтүүлгийн системийг эрчим хүчний хэмнэлттэй шинэ технологиор сольж тохижуулах боломжтой. Шинэ гэрэлтүүлгийн системийг суурилуулахдаа хамгийн сүүлийн үеийн батлагдсан эрчим хүчний хэмнэлттэй технологийг ашиглана.
- Барилгын гадна талын гэрэлтүүлгийг автомашины зогсоол, талбай, барилгын орц орчмын аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангахад тохирох хэмжээний гэрэлтүүлгийн түвшинд байлгах шаардлагатай. Эдгээр удирдамжийн хүрээнд эрчим хүчний менежментийн сайн туршлагуудыг ажиглаж, ашиглана.

Ажилтнуудыг тухайн орчинг хэдэн минутаас илүү хугацаагаар эзэнгүй орхих бол гэрлээ унтрааж байхыг зөвлөдөг. Энэхүү зан үйлийг дэмжихийн тулд гэрлийн унтраалга бүр дээр мэдэгдлийг байрлуулдаг. Өрөөнүүдэд хүнгүй үед гэрэл автоматаар унтардаг мэдрэгчтэй гэрэлтүүлгийн систем суурилуулах боломжтой.

4/ Хог хаягдал

4.1/ Аюулгүй хог хаягдал

Аюулгүй ердийн хог хаягдал гэдэгт ердийн үед оффисын зориулалттай хогийн саванд хаясан цаас, картон, полистирол, хуванцар сав баглаа боодлын материал, бага хэмжээний хүнсний хог хаягдал, шил, лааз гэх мэт зүйлс болон гудас, тавилга, Байгууламжийн удирдлагуудаар дамжуулан цуглуулж, хаяж буй лабораторийн бохирдолгүй тоног төхөөрөмж гэх зэрэг том овор хэмжээ бүхий зүйлсийг оруулж болно.

4.2/ Аюултай хог хаягдал

Аюултай хог хаягдал гэж хадгалах, цэвэрлэх, устгахад хүндрэлтэй бөгөөд аюултай гэж тооцогддог хог хаягдлыг хэлэх бөгөөд тэдгээр хог хаягдлыг сайтар хараа хяналттайгаар удирдах шаардлагатай. 1990 оны Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хяналттай хог хаягдлыг, үүний дотор аюултай хог хаягдлыг импортолдог, үйлдвэрлэдэг, авч явдаг, хадгалдаг, цэвэрлэдэг, устгадаг бүх хүмүүст

 <p>ВМНАГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ</p>	<p>№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй</p>
--	---	--


"Анхааралтай байх үүрэг" ногдуулдаг. Тус хуулинд аюултай хог хаягдлын анх үйлдвэрлэх үеэс эхлэн эцсийн цэг рүү хүргэх хүртэл тасралтгүй хянахыг шаарддаг.

4.2.Тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах

Энэхүү бүлэгт НУТ-ны 7.1.3-р бүлэгт заасан "Дэд бүтэц" буюу тоног төхөөрөмж, машин механизмын нөөцийн шаардлагыг хангах үйл явцыг тодорхойлов.


Тайлбар: Тээврийн хэрэгслийн нөөцийг энэ бүлэгт хамруулан авч үзсэн.

4.1.6. Тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангах

	<p>№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй</p>
---	---	--

4.1.6.2. Тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангах үйл явцын схемийн тайлбар

1	Үйлдвэр сургалтанд ашиглах ММТТ-д тавигдах, чанар, аюулгүй ажиллагаа, байгаль орчны болон бусад техникийн шаардлагыг тодорхойлно.
2	ММТТ-ийг худалдан авах гэрээнд чанар, аюулгүй ажиллагаа, байгаль орчны болон бусад техникийн шаардлагыг тусгана.
3	Худалдан авсан тоног төхөөрөмжийг техникийн баримт бичигт заагдсаны дагуу суурилуулж акт үйлдэнэ. Суурилуулалтыг ханган нийлүүлэгч байгууллагын мэргэжлийн инженерүүдийн заавраар гүйцэтгэнэ .
4	Тоног төхөөрөмжийг техникийн баримт бичигт заагдсаны дагуу суурилуулсаны дараа мэргэжлийн инженерийн хяналт зааврын дагуу ажиллуулж туршиж, зүгшрүүлж акт үйлдэнэ.
5.	Суурилуулагдсан тоног төхөөрөмж, машин механизм дээр ажиллах ажилтныг тодорхой хугацаагаар ажиллуулж дадлагажуулж энэ тухай акт үйлдэнэ.
6.	Суурилуулагдсан тоног төхөөрөмжүүд, машин механизмуудад техникийн паспортонд заасны дагуу техникийн үйлчилгээ хийж паспортонд тэмдэглэнэ.
7	Тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалтын үед аюулгүй ажиллагааны үзлэг хийж эвдрэл гэмтлийг оношлоно.
8.	Тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалтын үед аюулгүй ажиллагааны үзлэг хийж эвдрэл гэмтлийг засварлаж техникийн паспортонд тэмдэглэл хийнэ .
9.	ТҮ, урсгал засвараас гарсан тоног төхөрөмж машин механизмыг томилогдсон техникийн комисс шалгаж хүлээн авч актаар баримтжуулна

	№ Ж-3-017 Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-02-11 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	--	---

4.1.6.1. Үйл явцын схем

Оролт	Үйл явц	Оролцогч талууд							Гаралт
		Захи Рал	ХАББО	Нэгж удирдлага	ИТА - ууд	Хүний нөөц	Сан Хүү	Хан Гамж	
45001 7.1. Шаардлага	ММТТ-н үзүүлэлт		Оролц		Хийх				Паспорт
Тех.шаардлага	Худалдан авах				Хийх		Оролц	Оролц	ММТТ
Ммтт	Суурилуулах		Оролц	Оролц	Хийх				Акт
Акт	Турших			Оролц	Хийх				Акт
Акт	Сургах		Оролц		Хийх				Акт
Паспорт	Техник үзлэг хийх				Хийх				Акт
Акт	Тэнсэн эсэх	Батлах			Хийх		Оролц		Төсөв
Төсөв	Засварлах			Оролц	Хийх		Оролц	Оролц	Актууд
Актууд	Хүлээн авах		Оролц	Оролц	Хий				Актууд

	№ Ж-3-017	Баталсан огноо: 2026-02-11
	Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Хувилбар: V1.2026


4.1.7. Авто машин, тусгай зориулалтын машин механизм ашиглах

Авто машин, тусгай зохиулалтын машин механизм, тоног төхөөрөмж ашиглалтын үндсэн үйл явцын зураглалыг дор үзүүлэв.

4.1.7.1. Үйл явцын схем

Үндсэн үйл явц нь тухайн ажлыг гүйцэтгэхэд ямар шат дараалсан алхмуудаар, хэн хаана яаж оролцож гүйцэтгэхийг товч тодорхойгоор дүрслэн үзүүлсэн болно. Томилогдсон ажилтан үйл явцын үе шатанд бие даан болон холбогдох хүмүүстэй зөвлөлдөн багаар ажиллана.

Хүснэгт 1. Түрээсийн авто машин, тусгай зориулалтын машин механизм тоног төхөөрөмж ашиглалтын үйл явцын дараалал

Оролт	Процесс	Оролцогч талууд					Гаралт
		Захи Рал	ХА ББ О, Чан ар	Нэгж удирд лага	ИТА -ууд	Хан Гам ж	
Хэрэгцээ шаардлага	 <p>1. Авто машин, тусгай зориулалтын машин механизм тоног төхөөрөмжийн судалгаа хийх</p>	Хяна	Хян а	Орол ц	Хийх		Судалгааны үр дүн
Судалгааны үр дүн	2. Сонгон шалгаруулалт хийх	Хяна	Хян а	Орол ц	Орол ц	Хий х	Сонгогдсон байгууллага
Сонгогдсон байгууллага	3. Сонгогдсон байгууллагатай гэрээ хийх	Батал	Хян а	Хяна		Хий х	Батлагдсан гэрээ
Батлагдсан гэрээ	4. Гэрээт байгуулагуудыг захиалгат ажилд бэлэн байлгах	Хяна	Хян а	Хяна		Хий х	Хяналтын хуудсаар үзлэг хийх



№ Ж-3-017

Нөөцийн бэлэн байдлыг хангах хянах журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-02-11

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

Хяналтын хуудсаар үзлэг хийх	5. Авто машин, тусгай зориулалтын машин механизм тоног төхөөрөмжүүдийг бүртгэн авч, ажилд бэлэн байлгах						Бүртгэл Авто бааз/ гараж
Бүртгэл Автобааз/ гараж	6. Захиалга авах						Захиалгын хүсэлт
Захиалгын хүсэлт	7. Захиалгыг хувиарлах						Захиалгын хуваарь
Захиалгын хуваарь	8. Ажил гүйцэтгэлийн замын хуудсыг батлах						Батлагдсан замын хуудас
Батлагдсан замын хуудас	9. Ажил гүйцэтгэлийн төлбөрийг батлах						Батлагдсан төлбөрийн хуудас
